


# CMM GUIDE: M-OTC MARKET

№: 004

2025 оны 1 сар



## ХУРДАЦТАЙ ТЭЛЖ БҮЙ БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ

Зөвхөн 2024 онд ₮1.7 их наядын бонд боссон биржийн бус зах зээлийн талаар таны мэдэх ёстой бүх зүйлс

Монголд бүртгэлтэй нэг жилээс доошгүй үйл ажиллагаа явуулсан бүх компаниуд ББЗЗ дээр хаалттай бонд гаргах боломжтой.

5 хүртэл хөрөнгө оруулагчтай урьдчил үнэн тохирсон бол хялбаршуулсан байдлаар хаалттай бонд гаргаж болно.

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд үнэт цаасны төслийн танилцуулга боловсруулахгүйгээр бонд гаргах боломжтой.

2024 онд нийт бодитоор татан төвлөрүүлсэн дүнгийн 28% буюу ₮475 тэрбумыг 46 ББСБ татжээ.

Боловсрол, эрүүл мэнд, барилгын салбарын компаниудын бонд хамгийн өндөр хүүтэй байна.

Компаниуд ББЗЗ дээр 1-2 сарын дотор хөрөнгө татах боломжтой.

### “РЕДАКЦЫН ЗУРВАС”

Capital Markets Mongolia (CMM)-н эрхлэн гаргадаг CMM GUIDE мэргэжлийн сонины энэ удаагийн дугаарт “M-OTC Market” буюу Монголын биржийн бус зах зээлийг онцолж байна.

Дөрөв хүрэхгүй жилийн дотор ₮4.2 их наядын үнэт цаас бүртгэгдсэн энэ зах зээл нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж, компанийн санхүүжилт босгох томоохон талбар болоод буй.

Энэхүү дугаар нь биржийн бус зах зээлд ямар томоохон боломжууд байгааг таниулахын сацуу танай компанийг ББЗЗ-д хэрхэн оролцох хөтөч нь болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Дугаарын эрхлэгч: Э.Эрхэмзаяа  
erkhemzaya@capitalmarkets.mn



# 2025 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Олон улсад банк, санхүүгийн байгууллагууд, зохицуулагч болон судалгааны институтууд дэлхийн, бүс нутгийн болон улс орнуудын ирэх жилийн эдийн засгийн ерөнхий төлөв байдал, эрсдэлийн талаарх төсөөллөө танилцуулдаг уламжлалтай. Монгол улсад энэхүү туршлагыг идэвхитэй нэвтрүүлж харилцагчдадаа нээлттэй танилцуулдаг банк, санхүүгийн байгууллагуудын нэг нь ХААН банк билээ.

## 2024 оны төсөөлөл ба хэрэгжилт

ХААН банкны хувьд 2024 оны эдийн засгийн төлөв байдлын тайлангаа “Тэнцвэрийн дараах сорилтууд” гарчгийн дор тус оны эхэнд харилцагч байгууллагууддаа танилцуулсан билээ. Эдийн засгийн төсөөлөл гаргадаг ихэнх байгууллагын зүгээс 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байх талаар оны эхэнд гаргасан тайландаа дурдаж байв. ХААН Банкны хувьд ч 2024 онд эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллөө 6.5% байхаар танилцуулсан. Хөдөө аж ахуйн салбарт учирсан хүндрэлийг эс тооцвол эдийн засагт эерэг дүр зураг давамгайлсан, эдийн засгийн үзүүлэлтүүд тогтворжсон жил боллоо.

## ХААН банкны 2024 оны онцлох 10 төсөөлөл

1. Эдийн засгийн сэргэлт үргэлжилнэ
2. Инфляц Монголбанкны зорилтоос өндөрт хадгалагдана
3. Мөнгөний бодлогын төлөв алгуур зөөлөрнө
4. Валютын зах зээл тогтвортой байна
5. Экспортын өсөлт үргэлжилнэ
6. БНХАУ-н эдийн засаг сэргэнэ
7. Банкны системийн хөрвөх чадвар сайжирч, санхүүжилтийн олдоц нэмэгдэнэ
8. 2024 онд түүхэн сонгуулийн жил болно
9. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарна
10. Геополитикийн эрсдэл өндөр түвшинд хадгалагдана

## Төсөөллийн зөрүү

Хөдөө аж ахуйн салбарт үүссэн хүндрэл нь төсөөллийн зөрүүг үүсгэв. 2024 оны 3-р улирлын байдлаар бодит эдийн засаг 5% өсөлт үзүүллээ. Үүнтэй холбоотойгоор Монголбанкны зүгээс эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд хангах, бизнесийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг 3%-иар буулган 10%-д хүргэв.

Гадаад орчны хувьд авч үзвэл, БНХАУ-н мөнгөний болон сангийн бодлого үл хөдлөх салбарын сэргэлтэд хангалттай нөлөөгүй хэвээр байна. Мөн томоохон улс орнуудын инфляцын өсөлт саарч, төв банкнуудын зүгээс мөнгөний бодлогоо сулруулж, глобал эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа зэрэг нь 2024 оны төсөөллийн гол зөрүүг илэрхийлж байна.

## 2025 оны эдийн засгийн төлөв байдал

2025 оны хувьд Монгол улсын эдийн засагт голчлон уул уурхайн салбар, түүнийг дагасан үйлчилгээний салбарын өсөлт үргэлжлэх хүлээлтээр 7.0%-д хүрэх суурь төсөөлөлтэй байна. 2025 онд Монголбанкны мөнгөний бодлогын зөөлөн төлөв үргэлжлэх, улсын төсвийн бодлого сулрахаар байгаа нь ирэх оны эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна. Нөгөөтэйгүүр эдийн засгийн идэвхжил, Засгийн газар болон өрхийн хэрэглээний өсөлт нь инфляцыг өдөөж, Монголбанкны зорилтын дээд түвшинд хэлбэлзэх хүлээлтийг үүсгэж байна.

## ХААН банкны 2025 оны голлох төсөөллүүд

### 1. Эдийн засгийн өсөлт хадгалагдана

2025 онд экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний эрэлт хадгалагдаж, уул уурхайн салбарын өсөлт үргэлжлэх хүлээлттэй байна. Түүнчлэн экспортыг дэмжих бүтээн байгуулалт ирэх онд эрчимжихээр байгаа нь тээвэр, үйлчилгээний салбарын өсөлтөд эергээр нөлөөлөхөөр байна.

### 2. Экспортын өсөлт үргэлжилнэ

Экспортын гол эрэлтийг тодорхойлж буй БНХАУ-н аж үйлдвэрлэлийн идэвхжил эрчимжсэн тохиолдолд тус улсын нүүрсний импортын хэмжээ үргэлжлэн нэмэгдэх боломжтой. Нөгөө талаас Монгол улсын Засгийн газрын зүгээс “Шинэ сэргэлтийн бодлого”-н хүрээнд төмөр замын бүтээн байгуулалтын ажлуудыг тусган ажиллаж байна.

### 3. Түүхэн тэлэлт хийж буй төсөв

2025 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт ₮12.1 их наядын төсөвт өртөг бүхий 628 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь хамгийн өндөр дүнгээр төсвийн хөрөнгө оруулалт хийх жил болж байна. Мөн Засгийн Газрын зүгээс бүтээн байгуулалттай холбоотой мега төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, цалин ба тэтгэврийг нэмэгдүүлэхээр байгаа нь өрхийн хэрэглээг өсгөж, дотоод эрэлтийг дэмжих хүлээлттэй байна.

### 4. Глобал хүүгийн түвшинтэй зэрэгцэн бодлогын хүү үргэлжлэн буурах ч өндөр түвшинд удаан хадгалагдана

Олон улсад геополитикийн эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэхээс гадна инфляц төв банкуудын зорилтоос өндөрт хадгалагдаж байгаа нь гадаад суурь хүү өмнөх төсөөллөөс удаан буурахад нөлөөлж байна.

### 5. БНХАУ-н эдийн засгийг тойрсон тодорхой бус байдал нэмэгдэнэ

Өмнө жил хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ хүлээлтэд хүрэх эсэх нь тодорхой бус байгаагаас гадна АНУ-тай удаан хугацаанд үргэлжилж буй худалдааны дайн цаашид хэрхэх эсэх эрсдэл нэмэгдэж байна.

### 6. Ханш тогтвортой байна

Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдал өндөр, 2025 онд төлөгдөх томоохон бондын төлбөр байхгүй байгаа нь гадаад валютын ханшид ирэх дарамтыг бууруулахаар байна. 2025 онд төгрөгийн ханшид томоохон шокийн хөдөлгөөн гарахгүй бөгөөд 2-3% интервалд тогтвортой арилжаалагдах төлөвтэй байна.

### 7. Монгол улс олон улсын тавцанд

Монгол улсын зээлжих зэрэглэл нэг зэрэглэлээр өссөн нь Засгийн газар гадаад өрийн зохистой удирдлага хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэхээр байна.

### 8. Санхүүгийн нөхцөл суларна

2025 онд банкны салбарын нийт зээлийн өсөлт саарах боловч гол өсөлтийг бизнесийн зээл бүрдүүлэхээр байна.

### 9. Инфляц эргэн ирнэ

Мөнгөний болон төсвийн зөөлөн бодлого давхцаж буй нь дотоод эрэлтээс үүдэлтэй инфляцыг өдөөх эрсдэл өндөр байна. Мөн импортын барааны инфляцад үзүүлэх нөлөө нэмэгдэх төлөвтэй.

### 10. Геополитикийн эрсдэл

АНУ болон БНХАУ-н хоорондын технологийн өрсөлдөөн, худалдааны дайны асуудал нь дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж байна.


### 11. Цаг уурын эрсдэл

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ган, зудын эрсдэл нэмэгдэж байна. Төрөөс цаашид ногоон салбар болон эрчим хүчний хэмнэлт зэрэг тусгай нөхцөлүүдийг мөрдүүлэх төлөвтэй байна.

### 12. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн бүтээмжийн өөрчлөлт сүүлийн гурван улирал дарааллан сөрөг үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх хэсгийг залуучууд бүрдүүлж байгаа энэ үеийг оновчтой ашиглахад анхаарсан бодлого хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

2025 оны эдийн засгийн төлөв байдлын тайланг бүрэн эхээр нь унших бол доорх QR кодыг уншуулаарай.







# БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ (OTC MARKET) ГЭЖ ЮУ ВЭ?

Биржийн Бус Зах Зээл (ББЗЗ) нь компаниудын цаг хугацаа, зардлыг хэмнэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасаа санал болгон, богино хугацаанд санхүүжилт татах боломжийг олгодог.

Монголд ББЗЗ-ийн хууль, эрх зүйн орчин 2021 онд бүрдэж, тус оны 9 дүгээр сард үнэт цаасны анхны арилжаа эхэлж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар биржийн бус зах зээл дээр нийт 149 компанийн ₮4.2 их наядын үнэт цаас бүртгэгдэж, бодитоор ₮3.4 их наядыг төвлөрүүлжээ.

Манай улсын хувьд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргасан үнэт цаасыг арилжаалах ББЗЗ-ийг "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" ӨЗБ удирдан зохион байгуулдаг.

## Банк Бус Санхүүгийн Байгууллага (ББСБ)-ууд ББЗЗ дээр идэвхтэй байна

ББЗЗ дээр 2024 онд нийт 95 компани бодитоор ₮1.7 их наядыг татан төвлөрүүлсэн ба үүний 28% буюу ₮475 тэрбумыг 46 ББСБ бүрдүүлжээ.

2024 оны үзүүлэлт

Компанийн тоо	Салбар	Бодитоор татан төвлөрүүлсэн дүн* тэрбум төгрөгөөр	Хүүгийн түвшин**		
			бага	голч	их
46	ББСБ	475	16.5%	18.8%	21.5%
2	Эрчим хүч	398	19%	19%	19%
16	Худалдаа, үйлчилгээ	92	17%	18.5%	20%
9	Барилга	89	19%	20%	22%
8	Санхүү	87	16%	18.4%	21.8%
5	Уул уурхай	54	19%	20%	21%
1	Хөдөө аж ахуй	15	20%	20%	20%
3	Үйлдвэрлэл	9	19%	19.3%	20%
1	Мэдээлэл, холбоо	9	18%	19%	20%
2	Боловсрол, эрүүл мэнд	3	23%	23%	23%

\* Нийслэлээс гаргасан бонд болон Хөгжлийн банкны гаргасан бондыг хасч тооцов.

\*\* Хөрөнөө оруулагчтай харилцан тохиролцон багаар тооцсон хүүгийн түвшинг хасч тооцов.

Sponsored by



ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ  
ТУУШТАЙ БАЙДЛААР ►►

## БИДНИЙ ТУХАЙ:

Бид харилцагч байгууллагуудынхаа бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, шинэ боломжуудыг нээхэд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн өргөн боломжуудыг санал болгодог бөгөөд аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн санхүүгийн хэрэгцээнд нийцсэн өргөн хүрээний үйлчилгээг үзүүлж, харилцагчдынхаа амжилтын түнш байхыг эрхэмлэдэг.

## ҮЙЛЧИЛГЭЭ:

- Гадаад арилжаа
- Бондын хөрөнгө оруулалт
- Уул уурхайн брокер
- Дотоод арилжаа
- Санхүүжилт татах (андаррайтер)
- Хөрөнгө оруулалтын зөвлөх

## ББЗЗ 2024 ОНД



**95 компани**  
үнэт цаасаа бүртгүүлсэн



**₮1.7 их наяд**  
бодит татан төвлөрүүлсэн дүн



**3000 гаруй**  
бүртгэлтэй мэргэжлийн хөрөнгө оруулагч

## ББЗЗ-ийн арилжаанд хэн оролцох боломжтой вэ?

### Мэргэжлийн хөрөнгө оруулагч

- Сүүлийн 1 жилийн сарын дундаж орлого нь ₮10 саяас их, эсхүл
- ₮500 саяас дээш цэвэр хөрөнгөтэй, эсхүл
- Сүүлийн 1 жилийн турш гадаад болон дотоодын зах зээлд үнэт цаасны арилжаа хийж байсан туршлагатай Монгол улсын иргэд.

### Хуулийн этгээд

- ₮2.5 тэрбумын борлуулалтын орлоготой,
- ₮1 тэрбумаас доошгүй өөрийн хөрөнгөтэй хуулийн этгээд.

### Бусад

Төрийн байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд.

## ББЗЗ-ИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

### Богино хугацаанд хөрөнгө татах боломж

Нээлттэй бондтой харьцуулахад ББЗЗ дээр харьцангуй богино буюу 1-2 сарын дотор хөрөнгө татах боломжтой.

### Санхүүжилтийн өртөг бага

Хаалттай бонд гаргахад маркетингийн зардлыг хэмнэнэ. Мөн үнэт цаас бүртгүүлэх үйлчилгээний хөлс Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр бонд гаргахтай харьцуулахад 2 дахин бага. /ББЗЗ - 0.05%, МХБ - 0.1% (₮20 тэрбум хүртэлх үнийн дүнгээс)/

### Шалгуур, шаардлага бага


СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл авах шаардлагагүй ба үнэлгээ, хуулийн компанийн дүгнэлт заавал шаардахгүй.

Түүнчлэн нээлттэй бондын үнэт цаасны танилцуулга 400 хуудсаас илүүгүй гэж МХБ-ийн журамд тусгасан байдаг бол хаалттай бондын үнэт цаасны төслийн танилцуулга 28 хуудсаас илүүгүй байх зохицуулалттай.

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

# 9 САЛБАРЫН 20 ГАРУЙ КОМПАНИ

2024 оны байдлаар барилга, хүнс үйлдвэрлэл, санхүү, агаарын тээвэрт зэрэг 9 салбарын 20 гаруй компаниудтай хамтран ажиллаж нийт 600 гаруй тэрбумын төгрөгийн санхүүжилтэд ажиллаа.





# ББЗЗ ДЭЭР БОНД ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

ББЗЗ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д өөрчлөлт орохоор шинэчилсэн журмын төслийг 2024 онд хэлэлцсэн хэдий ч одоог хүртэл батлагдахыг хүлээсээр буй.

Тэгвэл энэ удаад бид одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ББЗЗ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хүрээнд бонд гаргагчийн шалгуур, шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, шимтгэл

хураамжийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргэхийн сацуу шинэчилсэн журмын төсөлд бонд гаргагчид хамааралтай аль үзүүлэлтүүд дээр өөрчлөлт орж буйг харьцуулан харуулж байна.

## Бонд гаргагчийн шалгуур, шаардлага

Дараах шалгуурыг хангасан компани биржийн бус зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд бондоо арилжаалах боломжтой.

### ХУУЛИЙН ЭТГЭЭД БАЙХ

- Монгол Улсад бүртгэлтэй
- Нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх

### АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайлан сүүлийн нэг жилийн хугацаанд аудитлагдсан байх

### ЗАРЦУУЛАЛТ ТОДОРХОЙ БАЙХ

Татан төвлөрүүлж буй хөрөнгийн зарцуулалт тодорхой байх

### БАРЬЦАА, БАТАЛГАА

- **Баталгаа:** Баталгааны дүн нь нийт бондын үүргийн дүнгээс багагүй байна.
- **Үл хөдлөх хөрөнгө:** Үнэт цаас гаргагчийн хүлээж буй нийт үүргийн үнийн дүнгийн 100-130%-иас багагүй хэмжээний үнэлгээтэй байх.
- **Хөдлөх хөрөнгө:** Үнэт цаас гаргагчийн хүлээж буй нийт үүргийн үнийн дүнгийн 100-150%-иас багагүй хэмжээний үнэлгээтэй.
- Эсхүл СЗХ-оос холбогдох зөвшөөрөл авсан этгээдээр санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон байх

### НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬД

Нээлттэй хувьцаат компани ББЗЗ дээр хаалттай бонд гаргах тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж болно.

Энэ тохиолдолд батлан даах хувьцаа нь үнэт цаас гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50%-иас дээшгүй байх.

### ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАГЧТАЙ БАЙХ

Өрийн хэрэгслийг худалдан авах хөрөнгө оруулагч нь тодорхой болоогүй бол Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай гэрээ байгуулсан байх

*Өрийн хэрэгслийн хувьд андеррайтер эсхүл үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн фирм үүргийн гүйцэтгэл хангуулагч байж болно.*

Хөтөлбөртэй бонд гаргах бол **хөтөлбөрийн нийт хугацаа 18 сараас багагүй байх.**

#### Шинэчилсэн журмын төсөлд

Хөтөлбөрийн нийт хугацаа 24 сараас багагүй байх ба өрийн хэрэгслийн хугацаа хөтөлбөрийн нийт хугацаанаас ихгүй байна.

## Бонд гаргах үе шат



1. ББЗЗ-ийн бүртгэлийн хороо нь үнэт цаасыг бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг гаргадаг ба аудит, хөрөнгийн үнэлгээ, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, ҮЦЗЗ, банк санхүүгийн зах зээлд 5-аас доошгүй жил ажилласан орон тооны болон орон тооны бус 5-аас дээш гишүүдээс бүрддэг.

2. Үнэт цаасны төслийн танилцуулгад хөрөнгө татах хугацааг тусгах зохицуулалттай.



# ББЗЗ ДЭЭР БОНД ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

## Бүрдүүлэх баримт бичиг



### Албан хүсэлт

Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээд болох ТУЗ, ХЭХ-ын шийдвэрийг хавсаргасан үнэт цаас бүртгүүлэх тухай албан бичгийг ББЗЗ-ийн бүртгэлийн хороонд хүргүүлнэ.

#### Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл

Маягт №2001

#### Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл

Маягт №2002

#### Андеррайтерын мэдэгдэл, дүгнэлт

Маягт №2003

#### Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн мэдэгдэл

Маягт №2004

Маягтуудтай эндээс танилцана уу.



Төслийн танилцуулга бичих заавартай эндээс танилцана уу.



#### Үнэт цаасны төслийн танилцуулга\*

Төслийн танилцуулга бэлтгэх заавар

#### Нотлох баримтууд

Төслийн танилцуулга бэлтгэх зааврын 3.6

Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан танилцуулга, мэдээллийн холбогдох нотлох баримт бичиг, хавсаргах материалууд.

**\*Дараах тохиолдолд үнэт цаасны төслийн танилцуулга боловсруулахаас чөлөөлөгдөж болно.**

1. Үнэт цаас гаргагч нь Засгийн Газар эсхүл Аймаг, Нийслэлийн Засаг Дарга, Монгол Улсын Хөгжлийн Банк байвал;

2. Үнэт цаас гаргагч нь биржид бүртгэлтэй, нээлттэй ХК ба тайлагналын болон засаглалын шаардлагыг бүрэн хангаж байгаа, СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагаас зөрчил арилгах тухай даалгавар, шийдвэр аваагүй хуулийн этгээд байвал;

3. Урьдчилан тохирсон 5 хүртэлх хөрөнгө оруулагчид үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан байвал тус тус үнэт цаасны төслийн танилцуулга боловсруулахаас чөлөөлөгдөнө.

## Шимтгэл, хураамж

### Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам		Шинэчилсэн журмын төсөл		
Үйлчилгээ			Шимтгэл	
Үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс	Бүртгэлийн хорооны хуралд шинээр хэлэлцүүлэх бүрд нэг	₮1,000,000	₮2,000,000	
	Бүртгэлийн хорооны хуралд давтан хэлэлцүүлэх бүрд нэг удаа	₮500,000	₮500,000	
Бүртгэлийн хураамж	Гаргаж буй үнэт цаасны үнийн дүнгээс нэг удаа төлнө. Доод дүн: ₮2,000,000 Дээд дүн: ₮10,000,000	0.05%		
		А самбар	Доод дүн: ₮1,000,000 Дээд дүн: ₮10,000,000	0.01%
		Б самбар	Доод дүн: ₮1,000,000 Дээд дүн: ₮30,000,000	0.05%
		С самбар (андеррайтертай)	Доод дүн: ₮1,000,000 Дээд дүн: ₮30,000,000	0.05%
С самбар (андеррайтергүй)	Доод дүн: ₮1,000,000 Дээд дүн: ₮50,000,000	1%		
Жилийн хураамж	Бүртгэлтэй байх хугацаанд хувь тэнцүүлэн жилийн эцэст нэг удаа	₮500,000		
		ББЗЗ-ийн бүртгэлд нэг жилээс бага хугацаатай үнэт цаас бүртгүүлсэн бол жилийн хураамжийг нэг жилээр тооцож нэхэмжилнэ.		

### Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Үйлчилгээ	Шимтгэл
Суурь бүртгэлийн хураамж Доод дүн: ₮1,000,000 Дээд дүн: ₮10,000,000	0.02%
Арилжааны төлбөрийн болон үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэх үйлчилгээний шимтгэл ₮1 тэрбум хүртэл: 0.0016% ₮1-5 тэрбум хүртэл: 0.0012% ₮5 тэрбумаас дээш: 0.0008%	0.0012%
Хадгаламжийн хураамж (жил)	₮400,000

### Оролцогч талуудын үйлчилгээний хөлс

Андррайтер компани*	Гэрээний дагуу
Аудитын компани	Гэрээний дагуу
Хуулийн фирм /шаардлагатай тохиолдолд**/	Гэрээний дагуу

\*Хөрөнгө оруулагч бэлэн тохиолдолд андеррайтергүй байж болно.

\*\*Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд байх нөхцөлд хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргуулна.

“А” самбар: Засгийн Газар, Аймаг, Нийслэлийн Засаг Дарга, Монгол Улсын Хөгжлийн Банк;  
“В” самбарт ББЗЗ-ийн ерөнхий болон үнэт цаасны нарийвчилсан шаардлагыг бүрэн хангасан үнэт цаасыг;  
“С” самбарт дараах тохиолдлын аль нэгд хамаарах үнэт цаасыг бүртгэнэ.

Үүнд:

- СЗХ-ны журам болон энэ журамд заасан гарааны бизнес эрхлэгчийн гаргасан үнэт цаас бол;
- Бүртгэлийн хорооноос бүртгэлийн шаардлага хангахтай холбоотой тодорхой хугацаатай үүрэг, даалгавар өгсөн эсхүл тодорхой нөхцөлтэйгөөр бүртгэсэн;

- Урьдчилан тохирсон 5-аас доош хөрөнгө оруулагчдад үнэт цаас эзэмшүүлэхээр тохирсон бөгөөд хөрөнгө оруулагчид үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан.





# ББЗЗ ДЭЭР БОНД ГАРГАХАД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ

## Андеррайтер сонгохдоо юуг анхаарах вэ?

### 01 Нетворк болон мэргэжлийн хөрөнгө оруулагчийн бааз суурь сайн эсэхийг судал

ББЗЗ дээрх үнэт цаасыг зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгох зохицуулалттай. Иймд хөрөнгө амжилттай татан төвлөрүүлэхэд андеррайтерын компанийн мэргэжлийн хөрөнгө оруулагчийн бааз суурь маш чухал.

### 02 Туршлага болон зах зээлд нэр хүнд сайн эсэхийг ажигла

Тухайн андеррайтерын компани өмнө нь ижил төстэй үнэт цаас гаргах төслийг хэр амжилттай хэрэгжүүлж байсан болон зах зээлд хэр нэр хүндтэйгээс шалтгаалан, үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад амжилттай санал болгох магадлал төдий чинээ их байх хандлагатай.

### 03 Санхүүгийн чадамж болон хүний нөөц хангалттай эсэхийг нягтал

Андеррайтер компани тогтвортой санхүүгийн чадамжтай байх нь үнэт цаас гаргагчийн шаардлагатай хөрөнгийг богино хугацаанд бүрдүүлж, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх боломж олгодог. Түүнчлэн хангалттай, чадварлаг хүний нөөцийн багтай байх нь хурдан хугацаанд үнэт цаас гаргах боломжийг нэмэгдүүлэх болно.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ЗӨВЛӨЖ БАЙНА



Н.НАРАНГЭРЭЛ  
/ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК/

### Аль болох хувьцаа барьцаалахгүй байх

Бондын үндсэн төлбөр, хүү хугацаандаа төлөгдөөгүйгээс үүргийн гүйцэтгэл хангуулах буюу барьцаа хөрөнгө, баталгаагаар хөрөнгө оруулагчдын хохирлыг барагдуулах ажилбар эхэлнэ.

Хэрэв үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн компани дампуурахад ойртож, хувьцаа нь хэдийнээ үнэ цэнээ алдсан байдаг тул үүргийн гүйцэтгэл хангуулах хэмжээнд хувьцааны үнэлгээ хүрдэггүй.

Иймд бонд гаргаж байгаа компаниас илүү эрсдэл бага, хувьцаа нь хөрвөх чадвартай компанийн хувьцааг барьцаалах, эсхүл үл хөдлөх хөрөнгө зэрэг өөр хөрвөх чадвартай хөрөнгө барьцаалах нь зохистой.

Хувьцаанаас өөр ямар төрлийн хөрөнгө барьцаалах боломжтой талаар андеррайтер компанитайгаа хамтарч шийдвэрлэх нь чухал.



Н.ДАНЗАНДАГВА  
/АРИЛЖААНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК/

### Борлуулалтын урьдчилсан төлөвлөгөө

ББЗЗ-д бонд гаргана гэдэг нь банкнаас нэг дор бүх санхүүжилтээ зээлээр авахтай огт адилгүй бөгөөд энэ нь хэд хэдэн мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татаж буй үйл ажиллагаа болохыг эхлээд ойлгох нь зүйтэй.

Компаниудад гэнэтийн мөнгөн хөрөнгийн хэрэгцээ үүссэний улмаас шинэ транчаар хөрөнгө татах хүсэлтээ 1-2 хоногийн өмнө андеррайтер компанидаа мэдэгдэх тохиолдлууд гардаг.

Энэ тохиолдолд андеррайтерт бонд худалдан авах бэлэн захиалга байхгүй бол борлуулалтын хугацаанаас хамаарч компанийн төлөвлөгөө сунжрах эрсдэл гарч болзошгүй юм.

Иймд компани өөрийн мөнгөн урсгалдаа тааруулан хөрөнгө татах төлөвлөгөө андеррайтертайгаа хамтран урьдчилан гаргаснаар төслийн төлөвлөгөөндөө цаг тухайд нь хүрэх давуу талтай болно.



П.СЭЛЭНГЭ  
/ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
БАНКНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
АПЕКС КАПИТАЛ ҮЦК/

### Эрх зүйн талаас юун дээр анхаарах хэрэгтэй вэ?

ББЗЗ-ээс хөрөнгө амжилттай татахад тухайн компанийн засаглалын тогтолцоо, үйл ажиллагаа нь хууль эрх зүйн хүрээнд явж чадаж байгаа эсэх нь чухал үзүүлэлт болдог.

Иймд компанийн хувьд дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх хэрэгтэй. Үүнд:

1. Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог журмаараа тодорхойлж, эрсдэлтэй нөхцөл бий болсон тохиолдолд тохирсон арга хэмжээг цаг алдалгүй авахыг урьдчилан тооцож гаргасан байх

2. Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмаар шийдвэрлэх нь үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ хэлцэл нь ирээдүйд хүчин төгөлдөр бус гэж тооцогдох эрсдэлээс хамгаалах хамгаалалт болдог.


## Sponsored by



Голомт Капитал ҮЦК ХХК 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр 2.5 их наяд гаруй төгрөгийн хэлцлийг амжилттай хэрэгжүүлж буй зах зээлдээ тэргүүлэгч компани юм.


Бид гадаад, дотоод арилжаа, хөрөнгө оруулалтын банк, бонд, IPO болон FPO хэлцлийн андеррайтер, уул уурхайн брокерийн үйлчилгээ зэрэг хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагч нартаа санал болгож байна.

## ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ



ББЗЗ бий болсноос хойш /2021-2024/

## БОНД ГАРГАГЧИЙН БАГЦ



## ОНЦЛОХ БОНДЫН ТӨСЛҮҮД



БӨӨРӨЛЖҮҮГИЙН  
ЦАХИЛГААН СТАНЦ

480 тэрбум₮



ШУНХЛАЙ ШАТАХУУН  
ИМПОРТЛОГЧ

100 тэрбум₮



ХАН АЛТАЙ АЛТНЫ  
ҮНДСЭН ОРД

55 тэрбум₮



ТЭРГҮҮЛЭХ БЭСБ  
ИНВЕСКОР

50 тэрбум₮



ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨД  
ХӨРВӨХ БОНД

30 тэрбум₮

Бондын зөвлөхүүд

7012-1530, 8888-9183, 8083-6622, 8665-4422, 8665-1177

trader.golomtcapital.com

Golomt Capital аппликэйшн

www.golomtcapital.com



# БОНДЫН ХҮҮГ ТОГТООХОД ЮУГ АНХААРАХ ВЭ?

Хаалттай бондын хүүгийн түвшинг бодлогын хүү, инфляцын түвшин, банкны хадгаламжийн хүү гэх мэт суурь үзүүлэлтүүдээс гадна тухайн компанийн зах зээлд танигдсан байдал, нэр хүнд, эрсдэлийн түвшин, санхүүгийн чадамж, зах зээлийн трэнд зэрэг олон хүчин зүйлийг харгалзан тогтоодог.

Одоогийн байдлаар ББЗЗ дээрх дийлэнх бонд тогтмол хүүгийн түвшинтэй байгаа хэдий ч зах зээлийн нөхцөл байдал, компанийн үйл ажиллагааны онцлог, хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцүүлэн хувьсах байдлаар хүүг тогтоох боломжтой.

## Зээлжих зэрэглэлийн тухай

Зээлжих зэрэглэл нь аж ахуйн нэгж болон засгийн газрын өр төлбөрөө төлөх чадварыг үнэлдэг чухал ач холбогдолтой үзүүлэлт юм. Зээлжих зэрэглэл бол санхүүгийн ертөнцөд итгэлцлийг баталгаажуулдаг чухал "хэл". Энэ үнэлгээг зөв ойлгож, зөв ашиглах нь танай байгууллагыг ирээдүйд итгэлтэй алхахад тусална.

### Дотоодын зэрэглэл тогтоох байгууллагын давуу тал

Дотоодын зэрэглэл тогтоох байгууллагууд тухайн улсын эдийн засаг, зах зээлийн онцлогийг илүү нарийвчлалтай ойлгож, бодит үнэлгээ гаргадаг. Иймд дотоодын болон олон улсын оролцогчдын итгэлийг хүлээх, зах зээлд илүү тохирсон үнэлгээг бүрдүүлэх боломжийг бий болгодог.

1

**Компанийн нэр хүнд, зах зээлд танигдсан байдлаа эерэгээр ашигла**

Хөрөнгө оруулагчдад аль хэдийн танигдсан, нэр хүндтэй байх нь хөрөнгө оруулагчдын итгэх итгэл өндөр төдийгүй эрсдэлийн түвшинг бууруулах боломжтой. Энэ нь хүүгийн түвшинг харьцангуй багаар тогтоох боломж юм.

2

**Зах зээл дээрх хүүгийн трэндийг ажигла**

Төв банкны бодлогын хүү, банкнуудын хадгаламжийн хүү, инфляцын түвшин болон ББЗЗ дээр жиших компанийн хаалттай бондын хүүгийн түвшин, тэдгээрийн эрсдэлийн түвшинтэй харьцуулан хүүгийн түвшинг тогтоохыг зөвлөө.

3

**Зээлжих зэрэглэлээ тогтоолгож, санхүүжих чадавхаа бататга**

Гадаад болон дотоодын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрх буюу санхүүгийн чадавхаа тодорхойлуулах нь санхүүгийн эрсдэлийг бууруулж, хүүгийн түвшинг багасгах нэг хүчин зүйл болно.

### Зээлжих зэрэглэлийн ач холбогдол

Зээлжих зэрэглэл өндөр байх нь санхүүгийн амжилтын түлхүүр юм.

- Зээлдэгчид:** Өндөр зэрэглэл нь зээлийн хүүг бууруулж, санхүүжилтийн зардлыг багасгана.
- Хөрөнгө оруулагчид:** Зэрэглэл нь эрсдэлийг зөв үнэлж, хөрөнгө оруулах итгэлийг нэмэгдүүлдэг.
- Эдийн засаг:** Улсын зэрэглэл нь гадаадын хөрөнгө оруулалт татах, илүү таатай нөхцөлтэй зээл авахад нөлөөлнө.
- Бизнесийн итгэлцэл:** Зээлийн өндөр зэрэглэл нь түншүүд болон хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлдэг.
- Санхүүгийн төлөвлөлт:** Ирээдүйд санхүүгээ удирдах оновчтой аргачлалд тусална.


### Хэн, хэзээ ашигладаг вэ?

Зээлжих зэрэглэл нь зөвхөн засгийн газар, томоохон аж ахуйн нэгжүүдэд төдийгүй эдийн засгийн олон оролцогчдод хэрэгтэй:

- Банкнууд:** Томоохон зээлдэгч аж ахуйн нэгжид зээл олгох шийдвэр гаргахдаа ашигладаг.
- Хөрөнгө оруулагчид:** Бонд болон өрийн хэрэгслийн эрсдэлийг үнэлэх гол үзүүлэлт.
- Бизнесүүд:** Санхүүгийн нөхцөл тохиролцох, хөрөнгө оруулагчдыг татахад дэмжлэг болдог.
- Засгийн газрууд:** Санхүүжилт авах, бодлого боловсруулахдаа ашигладаг.
- Олон улсын **тендер** оролцох үед.
- Стратегийн** томоохон **шийдвэр** гаргах үед.
- Хууль эрх зүйн шаардлага хангах үед тус тус зээлжих зэрэглэлийг ашигладаг.

Мэдээлэл бэлтгэсэн: Ц.Мөнгөнтуяа - Ахлах шинжээч /Онч Кредит Рэйтинг ХХК/

Sponsored by



Онч Кредит Рейтинг Эйжинси ХХК нь 2023 онд байгуулагдсан Монгол дахь зэрэглэл тогтоох ууган байгууллагын нэг юм.

Бид санхүүжих чадавхын зэрэглэлийг үнэн зөв, бодитой тогтоосноор хөрөнгө оруулагчид болон бизнесүүдийг холбох гүүр болж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд хүч нэмэх болно.

### Онцлох төслүүд:



Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн зээлжих зэрэглэл ба компанийн зэрэглэлийн үнэлгээг "mнA" (Тогтвортой) тогтоов.



Сэндли ББСБ ХК-ийн зээлжих зэрэглэл ба компанийн зэрэглэлийн үнэлгээг "mнA-" (тогтвортой) түвшинд тогтоов.

### ХАРИЛЦАГЧИД ҮҮСЭХ ДАВУУ ТАЛУУД

- ✓ ЗАРДЛАА БАГАСГАХ
- ✓ ХУГАЦАА ХЭМНЭХ
- ✓ НЭР ХҮНДЭЭ БАТАТГАХ
- ✓ ЭРСДЛЭЭ ХАРЬЦУУЛАХ

### САНАЛ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ

#### БОНДЫН ЗЭРЭГЛЭЛ

Бондын зэрэглэл нь тухайн өрийн хэрэгслийн хувьд эргэн төлөгдөх чадавхыг харуулдаг бөгөөд бусад бондтой харьцангуйгаар хөрөнгө оруулахтай холбогдон харьцангуйгаар хөрөнгө оруулахтай холбогдон үүсэх эрсдлийг тодорхойлоход хөрөнгө оруулагчдад туслах зорилготой.

#### КОМПАНИЙН ЗЭРЭГЛЭЛ

Компанийн зэрэглэл нь тухайн байгууллага санхүүгийн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх магадлалын талаарх хараат бус дүгнэлт юм. Компанийн зэрэглэл нь төлбөр төлөх харьцангуй чадварыг харуулдаг.

#### ESG ҮНЭЛГЭЭ

Бид компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлд мэдрэг байдал, эрсдлийн удирдлагын чанарыг хөндлөнгийн, хараат бусаар үнэлдэг.

#### ДОТООД ҮНЭЛГЭЭ

Компанийн бизнес явуулах орчин, засаглал, эрсдэл болон санхүүгийн удирдлагын чанарт хөндлөнгийн, хараат бусаар хийх үнэлгээ юм.

Холбогдох утас: +976 70120450  
Цахим шуудан: info@onch-rating.mn

[www.onch-rating.mn](http://www.onch-rating.mn)

Нью Хоризонс 10 давхар 1001 тоот, Олимпын гудамж-4, Сүхбаатар дүүрэг 1р хороо, Улаанбаатар хот






# Capital Markets Mongolia

| Research

| Financial PR &amp; Communications

| Advisories

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТАНАЙ КОМПАНИЙГ ХӨТӨЛНӨ

CMM нь судалгаа, зөвлөх үйлчилгээ, ПР-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Бид харилцагч компаниудын хөрөнгө оруулагчидтай харилцах стратегийг оновчтой тодорхойлох, IPO хийх, бонд гаргах, ХЗЗ-с хөрөнгө татах, хаалттай хүрээнд хөрөнгө босгох мөн цаашлаад санхүүгийн зах зээл рүү чиглэсэн үр дүнтэй ПР, маркетинг хийх стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.



## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

- Гадаад хөрөнгө оруулагчид руу чиглэсэн судалгаа
- Зах зээлийн судалгааны ажлууд
- Хувьцааны судалгаа, товч танилцуулга
- ХЗЗ оролцогч талуудын судалгаа
- CMM Guide

## САНХҮҮГИЙН ПР

- IPO, Бондын PR, маркетингийн кампанит ажил
- Санхүү, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ олон нийтэд таниулах стратеги
- Roadshow, форум, вебинар, воркшоп зохион байгуулах
- Лого, визуал дизайн, уриа үгийн хөгжүүлэлт
- Медиа сувгуудаар мэдээлэл түгээх төлөвлөгөө болон цацалт

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- IR advisory цогц үйлчилгээ
- IR аутсорсинг үйлчилгээ
- Байгууллагын дотоод IR функц хөгжүүлэх, дотоод журам боловсруулах
- Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт татах
- Стратегийн зөвлөх үйлчилгээ (IPO, бонд г.м)
- Хөрөнгө оруулагчдын хандлагыг тодорхойлох судалгаа
- Workshop for Management

### БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ

 info@capitalmarkets.mn

 capitalmarkets.mn

 9921-0566

CMM-н бэлтгэн гаргадаг судалгаа, мэдээллийг тогтмол авахыг хүсвэл

